

БАТЛАВ:

БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ
УХААНЫ ЯАМНЫ
ТӨРИЙН НАРИЙН
БИЧГИЙН ДАРГА
Л.ЦЭДЭВСҮРЭН

БАТЛАВ:

ОРХОН АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГА
С.БАТЖАРГАЛ

БАТЛАВ:

“ЭРДЭНЭТ ҮЙЛДВЭР”
ТӨҮГ-ЫН ЕРӨНХИЙ
ЗАХИРАЛ Г.ЁНДОН

**ОРХОН АЙМАГ ДАХЬ “СУРГАЛТ-ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭ-ҮЙЛДВЭРЛЭЛИЙН
ЦОГЦОЛБОР”-ЫН ЕРӨНХИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ БОЛОВСРУУЛАХ
АЖЛЫН ДААЛГАВАР**

2023 он 03 сарын 27-ны өдөр

Дугаар/...../.....

Улаанбаатар хот

1	Ерөнхий төлөвлөгөө, боловсруулах үндэслэл	<ul style="list-style-type: none"> - Хот байгуулалтын тухай 7.1.5, 7.1.9, 8.1.1, 11.1.5, 12.5 дахь хэсэг, заалтууд; - Монгол Улсын Их хурлын 2020 оны 52 дугаар тогтоол, “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичиг; - Монгол Улсын Их хурлын 2020 оны 23 дугаар тогтоолоор батлагдсан “Монгол Улсыг 2021-2025 онд хэрэгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-ийн 2.4.3, 2.4.9 дэх заалт; - Монгол Улсын Их хурлын 2020 оны 24 дүгээр тогтоолоор батлагдсан Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.3.7, 2.5.11 дэх заалт; - Монгол Улсын Их хурлын 2021 оны 106 дугаар тогтоолоор батлагдсан “Шинэ сэргэлтийн бодлого”-ийн “Хот хөдөөгийн сэргэлт” зорилт 4.2.10; - УИХ-ын 2020 оны “Хот байгуулах тухай” 55 дугаар тогтоол; - Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 29 дүгээр тогтоол /Хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө батлах тухай/; - Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 321 тогтоолоор батлагдсан Их дээд сургуулийг “Сургалт-эрдэм шинжилгээ-үйлдвэрлэлийн цогцолбор” болгон орон нутагт хөгжүүлэх тухай; - Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 01 дүгээр сарын 11-ний өдрийн хуралдааны 03 дугаар тэмдэглэл; - Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн стратеги төлөвлөгөө;
---	---	--

2	Байршил, эдийн засаг, нийгмийн хөгжлийн байдал	<ul style="list-style-type: none"> - Орхон аймаг нь нийслэл Улаанбаатар хотоос 380 км зайд алслагдсан, 84400га газар нутугтай, 98000 хүн амтайгаас Эрдэнэт хот нь 25100 га газар нутагт 87837 хүн оршин суудаг улсын хэмжээнд хамгийн их хүн амын нягтралтай газар юм. - Орхон аймагт өнөөгийн байдлаар 37 цэцэрлэгт 7000 мянга гаруй хүүхэд, ерөнхий боловсролын 4 цогцолборын 20 сургуульд 20,000 орчим мянган хөвгүүд, охид суралцаж, мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвд 1358 гаруй мэргэжилтэй ажилчин бэлтгэгдэж байна. Мөн ШУТИС-ийн салбар Эрдэнэт цогцолбор дээд сургууль, Экологи, аялал жуулчлалын “Маргад” хувийн дээд сургуульд 3,000 гаруй оюутан суралцаж байна. - Улсын тээврийн сүлжээнд авто болон төмөр замаар холбогдсон. - Цогцолборын ерөнхий төлөвлөгөөний талбайн байршил нь Эрдэнэт хотын зүүн талд, хойд талаараа Төв зам, “Эрдэнэт хивс” ХХК болон Цагдаагийн Ерөнхий Газар, зүүн болон зүүн урд талаараа ДЦСтанц байрлана.
3	Хамрах хүрээ, газар нутгийн хэмжээ	<ul style="list-style-type: none"> - Орхон аймгийн Баян-Өндөр сум, Оюут, Баянцагаан багийн нутаг дэвсгэрт, цогцолборын үндсэн чиг үүргийг хэрэгжүүлэх талбай нь 50 га газар; /Хавсралт схем зураг/
4	Боловсруулах ажлын үе шат	<ul style="list-style-type: none"> - Хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг боловсруулахдаа дараах үе шатны дарааллаар хийнэ; Үүнд: - а/Хот байгуулалтын суурь судалгаа /2022 оны байдлаар/; - б/Байгаль орчны нарийвчилсан үнэлгээ; - в/Хот байгуулалтын иж бүрэн үнэлгээ; - г/Техник эдийн засгийн үндэслэл /инженер геологийн судалгаа/; - д/Хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө; - е/Хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө боловсруулах;
5	Боловсруулахад ашиглах материал	<p><u>Монгол Улсын хуулиуд:</u></p> <ul style="list-style-type: none"> - Хот байгуулалтын тухай хууль; - Барилгын тухай хууль; - Байгаль орчныг хамгаалах тухай хууль; - Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хууль; - Тусгай хамгаалалттай газар нутгийн орчмын бүсийн тухай хууль; - Бүсчилсэн хөгжлийн удирдлага зохицуулалтын хууль; - Усны тухай хууль; - Хот суурин газрын ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хууль; - Эрчим хүчний тухай хууль;

- Газрын тухай болон Монгол улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хууль;
- Геодези, зураг зүйн тухай хууль;
- Кадастрын зураглал ба газрын кадастрын тухай хууль;
- Орон сууцны тухай хууль;
- Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль;
- Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль;
- Боловсролын тухай хууль;
- Дээд боловсролын тухай хууль;
- Бусад холбогдох хуулиуд;

Бодлогын баримт бичиг, төсөл хөтөлбөрүүд:

- Монгол Улсын Их хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор батлагдсан “Алсын хараа-2050” хөгжлийн бодлогын баримт бичиг;
- Монгол Улсын Их хурлын 2021 оны 106 дугаар тогтоолоор батлагдсан “Шинэ сэргэлтийн бодлого”;
- Монгол Улсын Их хурлын 2020 оны 23 дугаар тогтоолоор батлагдсан “Монгол Улсыг 2021-2025 онд хэрэгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”;
- Монгол Улсын Их хурлын 2020 оны 24 дүгээр тогтоолоор батлагдсан Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр;
- Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 321 тогтоолоор батлагдсан Их дээд сургуулийг “Сургалт-эрдэм шинжилгээ-үйлдвэрлэлийн цогцолбор” болгон орон нутагт хөгжүүлэх тухай;
- Салбаруудын хэмжээнд хэрэгжиж буй бусад төсөл, хөтөлбөр, стратеги, төлөвлөгөөнүүд;
- Төрийн өмчийн их, дээд сургуулиудын стратеги төлөвлөгөө;

Нормативын баримт бичгүүд:

- Хот, тосгоны төлөвлөлт, барилгажилт (БНБД 30-01-21);
- “Хот байгуулалтын баримт бичиг боловсруулах заавар”(БД 30-10-21);
- Хот, суурин газарт хот байгуулалтын иж бүрэн үнэлгээ өгөх аргачилсан заавар (УББ 30-201-09);
- Хот суурины гудамж, зам төлөвлөлт (БНБД-32-01-04);
- “Хот, тосгоны хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний төслийг олон нийтээр хэлэлцүүлэх журам”;
- “Хот байгуулалтын кадастр” (БД 14-102-19);
- “Хот байгуулалтын Мэдээллийн сангийн үйл ажиллагааны журам” (БХБ-ын Сайдын 2019 оны 38 дугаар тушаал);
- MNS 6736:2018 “Хот байгуулалтын мэдээллийн сангийн таних тэмдэг”;

		<ul style="list-style-type: none"> - MNS 6056:2009, Явган хүн, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан зам; - MNS 5682-2006, Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн орон зайн төлөвлөлт барилгын дүрэм; - Авто зогсоол (БНБД 21-05-10); - Барилга, байгууламжийн инженер, экологийн судалгаа (БД 11-102-07); - Бусад холбогдох норм, дүрэм, заавар, стандарт; - Иргэний нисэхийн багц дүрмүүд; - Олон нийт иргэний барилга (БНБД 31-03-03); - Олон нийт иргэний барилга (БНБД 31-03-03*/11); <p><u>Судалгааны материалууд:</u></p> <ul style="list-style-type: none"> - Орхон аймгийн хөгжлийн цогц бодлого (2020-2030) он; - Барилгын хөгжлийн төвийн 2021 оны “Монгол улсын нийт нутаг дэвсгэр, хот суурин газруудын хот байгуулалтын үнэлгээ”; - Японы олон улсын хамтын ажиллагааны байгууллага /JICA/-ын 2016 оны “Монгол улсын бүсчилсэн хөгжлийн нэгдсэн судалгаа”; - Газрын зураглал /геодези, байрзүйн зураг/; - Инженер-геологийн хайгуулын судалгааны дүгнэлт; - Усны эх үүсвэр, нөөцийн судалгаа; - Геоморфологийн судалгаа; - Урьд хийгдсэн хөрсний болон усны хайгуулын судалгааны материал; - Газар хөдлөлийн бичил мужлалын зураг зохиох төслийн тайлан; - Газар хөдлөлийн бичил мужлалын судалгаа; - Бусад;
6	Баримт бичгийн бүрдэл	<p><u>Хот, төлөвлөлтийн суурь судалгаа, концепци загвар:</u></p> <ul style="list-style-type: none"> - “Хот байгуулалтын тухай” хуулийн 12.9 дэх заалт болон холбогдох норм, нормативын баримт бичгийн дагуу газар нутаг, хүн ам зүй, түүх, соёл, нийгэм, эдийн засаг, байгаль орчин, хөдөө аж ахуй, хот байгуулалт, газар ашиглалт, дэд бүтцийн болон бусад шаардлагатай судалгаа, дүн шинжилгээ хийх - Байр зүйн зураг /Ерөнхий төлөвлөгөөний дэвсгэр зураг/-ийг 1:2000 масштабтай боловсруулах; - Инженер-геологи, геотехникийн судалгаа /төлөвлөлтөд хамрагдах нийт талбайн хэмжээнд/, тайлан боловсруулах; - Хот байгууламжийн иж бүрэн үнэлгээ хийх; - Өмнө хийгдсэн судалгаа, төлөвлөлтийн баримт бичгүүдэд үнэлэлт, дүгнэлт өгөх; - Хот төлөвлөлтийн судалгаа, үнэлгээ, дүн шинжилгээнд тулгуурлан Сургалт- эрдэм шинжилгээ -үйлдвэрлэлийн цогцолборын

төлөвлөлтийн загвар, шийдлийг 2-оос доошгүй хувилбараар боловсруулах;

Зураглалын материал:

- Эрдэнэт хот болон Сургалт-эрдэм шинжилгээ-үйлдвэрлэлийн цогцолбор нь тухайн бүсийн дэд бүтцийн сүлжээнд хамрагдаж байгаа байдал, байршлын схем зураг M1:25000;
- Эрдэнэт хотын хөгжлийн тойм M1:10000;
- Хот байгуулалтын иж бүрэн үнэлгээ M1:5000;
- Одоогийн байдал /дэвсгэр зураг/ M1:2000;
- Хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний үндсэн зураг M1:2000;
- Нутаг дэвсгэрийн үүргийн бүсчлэл, зам тээврийн сүлжээ M 1:2000;
- Нийгмийн дэд бүтцийн үйлчилгээ, хамрах хүрээ M1:2000;
- Эдэлбэр газрын хуваарилалт, газар ашиглалтын зориулалт M1:2000;
- Инженерийн бэлтгэл арга хэмжээ, гадаргуугийн болон үер, хөрсний ус зайлуулах арга хэмжээ, нэгдсэн картограмм M 1:2000;
- Өндөржилт, улаан шугам M1:2000;
- Инженерийн шугам сүлжээний нэгдсэн зураг M1:2000;
- Дулаан хангамж M1:2000;
- Ус хангамж, ариутгах татуурга M1:2000;
- Цахилгаан хангамж M1:2000;
- Холбоо, дохиолол, интернет сүлжээ, камержуулалт M1:2000;
- Ногоон байгууламж, цэцэрлэгжүүлэлт, байгаль орчныг хамагаалах арга хэмжээ M1:2000;
- Гамшгаас хамгаалах төлөвлөлт M1:2000;
- Эхний ээлжийн барилгажилт, төвийн хэсгийн барилгажилт панорам, архитектур төлөвлөлт M1:1000;
- Макет M1:1000 /3D хэмжээст зураглал, анимейшныг тоон болон видео хэлбэрээр боловсруулна/;
- Тайлбар бичиг 4 хувь;

Зураг төсөлд тавигдах шаардлага:

- Зураг төслийг хот байгуулалтын мэдээллийн санд хүлээлгэн өгөхдөө Үндэсний зөвлөлдөх хорооны 2018 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн хурлаар батлагдсан MNS 6736:2018 стандартын дагуу хийх /ArcGIS программаар гүйцэтгэх;
- Батлагдсан (зураг төсөл, тайлбар бичиг)-г хэвлэмэл болон файл байдлаар (CD-нд бичиж) 5 хувь бэлтгэж, захиалагчид эх хувь 1, хуулбар 4 хувийг хүлээлгэж өгнө;

		<ul style="list-style-type: none"> - Тоон мэдээлэл, бичиглэлийн болон зураглалын материалыг *.doc, *.xls, *.PDF өргөтгөлөөр, байрзүйд суурилсан зураглалын материалыг *.dwg болон *.shp өргөтгөлтэй хүлээлгэн өгсөн байна;
7	Шийдвэрлэх үндсэн асуудлууд	<ul style="list-style-type: none"> - Суурь судалгаа, хот байгуулалтын иж бүрэн үнэлгээ өгсний үндсэн дээр Сургалт- эрдэм шинжилгээ -үйлдвэрлэлийн цогцолборын байршил, эдэлбэр газрын хэмжээг нарийвчлан тодорхойлох; - Байгаль экологийн, нийгэм эдийн засгийн, хот байгуулалт, архитектур орон зайн төлөвлөлт- ландшафтын хүчин зүйлийн иж бүрэн үнэлгээ хийсний үндсэн дээр хүн амын нийгмийн эрэлт хэрэгцээнд нийцсэн барилгажилт, тохижилт бүхий архитектур орон зайн зохистой бүтэц, эрүүл аюулгүй орчныг бүрдүүлэх; - Хот төлөвлөлт, газар зохион байгуулалтын уялдааг хангах; - Газар зохион байгуулалтын төлөвлөгөөтэй уялдуулан нутаг дэвсгэрийн газар ашиглалтын зонхилох зориулалтыг нарийвчлан тогтоож, хот байгуулалтын төлөвлөлтийн норм дүрмийн дагуу, газар ашиглалтыг үр ашигтай байхаар дараах үндсэн бүсүүдэд ангилан, Дижитал их сургуулийн онцлог хэв шинж, орчин нөхцлийг тооцон, төлөвлөлтийн шийдлийг боловсруулна. <ol style="list-style-type: none"> 1. Эрдэм шинжилгээ, сургалтын бүс <ul style="list-style-type: none"> - Их сургуулийн бүс - Эрдэм шинжилгээ, судалгааны бүс <ul style="list-style-type: none"> ▪ Эрчим хүч, автоматжуулалтын чиглэлээр ▪ Уул уурхай, геодези, маркшейдерын чиглэлээр ▪ Эрдэм боловсруулалт, баяжуулалтын чиглэлээр ▪ Металл судлал, механикийн чиглэлээр ▪ Экологи, тогтвортой хөгжлийн чиглэлээр ▪ Мэдээллийн технологи, Дата судалгааны чиглэлээр 2. Ногоон байгууламж, амралт зугаалгын бүс <ul style="list-style-type: none"> - Амралт зугаалга, хүрээлэнгийн бүс - Спорт амралтын бүс 3. Суурьшлын бүс <ul style="list-style-type: none"> - Ажилчдын байрны бүс - Оюутны байрны бүс - Зочид буудал 4. Худалдаа үйлчилгээний бүс <ul style="list-style-type: none"> - Худалдаа үйлчилгээний бүс 5. “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ын лаборатори, барилга байгууламжийн бүс

		<p>- “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ын лаборатори, барилга байгууламжийн бүс</p> <p>6. Нөөц талбайн бүс /дахин төлөвлөлтийн/</p> <ul style="list-style-type: none"> - Улаанбаатар хот, Эрдэнэт хот болон бусад хот, суурин газруудтай холбогдох зам, тээврийн сүлжээтэй уялдуулан тээврийн сүлжээг төлөвлөх; - Байгаль, цаг уур, газар зүйн нөхцөл, тухайн цогцолборын онцлогийг үндэсний хэв маягтай хослуулан тусгасан орон зайн өвөрмөц бүтэц бүхий архитектур, хот төлөвлөлтийн шийдэлд нийцүүлэн олон улсын жишиг, стандартад нийцсэн орчин үеийн “Ухаалаг хот” (Smart city), “Compact” хотын төлөвлөлтийн зарчмаар төлөвлөх; - Цэцэрлэг, сургууль, эмнэлэг, соёл, ахуйн үйлчилгээний төв, спорт цогцолбор зэрэг барилга байгууламжийн хүчин чадлыг нарийвчлан тогтоох - Олон нийт, соёл, үйлчилгээний төв нь барилгажилтын хувьд харилцан уялдаа сайтай, орон зайн харьцаа, архитектур төлөвлөлтийн хувьд цогцолбор байхаар төлөвлөх; - Авто, дугуйн, явган зам, гудамж, талбай, орц гарц болон барилга байгууламжид хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан, хүртээмжтэй нөхцөлийг бүрдүүлэх; - Ногоон байгууламж, цэцэрлэгт хүрээлэн, спорт амралт зугаалгын бүс, авто зогсоолын талбай, нөөц талбайг норм дүрмийн дагуу төлөвлөх; - Цогцолборын төлөвлөлтөд ухаалаг, хэмнэлттэй хотын үндсэн зарчмуудыг тусгах, нөхөн сэргээгдэх эрчим хүч, хүн болон байгальд ээлтэй арга, технологиудыг өргөн хэрэглэх бололцоог хангасан байдлаар тооцож төлөвлөх (барилгыг нарны тусгал ихтэй байхаар байршуулах); - Инженерийн бэлтгэл арга хэмжээ, үерийн хамгаалалтын болон хөрсний ус зайлуулах арга хэмжээг цогцолборын хэмжээнд иж бүрэн төлөвлөх, гадаргуугийн болон хөрсний усыг дахин ашиглах шинэ техник, технологийн оновчтой шийдлийг төлөвлөлтөд тусгах; - Борооны ус, боловсруулсан усыг дахин ашиглах шинэ техник, технологийн оновчтой шийдлийг төлөвлөлтөд тусгах; - Цогцолборын хог хаягдлын менежмент, хог дахин боловсруулах шийдлийг тусгах; - Гамшгаас хамгаалах, урьдчилан сэргийлэх гамшгийн үед авч хэрэгжүүлэх цогц арга хэмжээний хүрээнд газар хөдлөлтийн эрсдэл бүхий газарт биеийн тамирын талбай, цэцэрлэгт хүрээлэн, ногоон байгууламж зэрэг барилгажилт багатай бүсийг аль болох төлөвлөх зарчмыг баримтлах;
--	--	--

		<ul style="list-style-type: none"> - Хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулах; - Төлөвлөлтийн шийдлийг үе шатаар хэрэгжүүлэх арга хэмжээг тодорхойлон, хөрөнгө оруулалтын урьдчилсан тооцоог гаргаж, хөрөнгө оруулалтын эх үүсвэрийг хэрхэн шийдвэрлэх талаар санал боловсруулах;
8	Инженерийн байгууламж, шугам сүлжээний эх үүсвэр, хангамж	<ul style="list-style-type: none"> - Инженерийн хангамж (дулаан, ус хангамж, ариутгах татуурга, цахилгаан, холбоо)-ийн эх үүсвэр, шугам сүлжээний эх үүсвэрийн одоогийн хэрэглээнд үнэлэлт, дүгнэлт өгсний үндсэн дээр цаашдын хөгжлийн төлөв, хэрэгцээтэй уялдуулан тооцож үндсэн шийдлийг тодорхойлон, хэрэгжүүлэх ээлж дарааллыг тогтоох. Үүнд: - Инженерийн хангамжийн нэгдсэн шийдлийг эдийн засгийн тооцоо, судалгаанд үндэслэн боловсруулах; - Инженерийн хэсэгчилсэн хангамжийн төлөвлөлт, харьцуулалт, эдийн засгийн үр ашгийг тооцож, оновчтой хувилбарыг сонгох, инженерийн хангамжийн хэсэгчилсэн эх үүсвэрийг нэвтрүүлэх, бодлогыг тодорхойлох; - Орчин үеийн шинэ дэвшилтэт техник технологийн шийдэл бүхий бага оврын цэвэрлэх байгууламж, эрчим хүчний бие даасан системийг судлан шийдвэрлэх; - Эрчим хүчний хэрэглээнд сэргээгдэх эрчим хүч, хийн хангамжийн шийдлүүдийг тусгах, эдийн засгийн үр ашгийг тооцох; - Цогцолборын төвийн хэсгийн инженерийн шугам сүлжээг хонгилын системээр төлөвлөх; <p><u>Дулаан хангамж:</u></p> <ul style="list-style-type: none"> - Одоо байгаа дулааны нэгдсэн эх үүсвэрээс хангагдахаар төлөвлөх, хог хаягдал болон байгальд ээлтэй бусад технологиудыг дулаан хангамжийн төлөвлөлтийн шийдэлд санал болгох; <p><u>Ус хангамж:</u></p> <ul style="list-style-type: none"> - Усны хайгуулын судалгаанд тулгуурлан эх үүсвэрийн нөөцийг тогтоож, төвлөрсөн усан хангамжид холбогдохоор төлөвлөх; <p><u>Ариутгах татуурга:</u></p> <ul style="list-style-type: none"> - Төлөвлөж буй цогцолборын барилга байгууламжийн ариутгах татуургын төвлөрсөн шугам сүлжээ, цэвэрлэх байгууламжийг орчин үеийн дэвшилтэт технологийн дагуу төлөвлөх; <p><u>Цахилгаан хангамж:</u></p> <ul style="list-style-type: none"> - Цогцолборын цахилгаан эрчим хүчний хэрэгцээг тодорхойлон, Хөгжлийн ерөнхий төлөвлөгөөтэй уялдуулан төлөвлөх (Нар, салхи зэрэг сэргээгдэх эрчим хүчний том хүчин чадалтай цахилгаан

		<p>станцуудын өртөг зардал хямд байгааг төлөвлөлтөд харгалзах);</p> <p><u>Авто зам, тээвэр</u></p> <ul style="list-style-type: none"> - Зам, тээврийн сүлжээг улс, бүс нутаг, орон нутгийн зам, тээврийн дэд бүтэцтэй уялдуулан төлөвлөх; <p><u>Холбоо мэдээлэл:</u></p> <ul style="list-style-type: none"> - Мэдээлэл холбооны өндөр хурдны сүлжээнд холбохоор төлөвлөх; - Инженерийн хангамжийг техникийн шийдлийг эдийн засгийн хувьд үр ашигтай орчин үеийн технологитой байхаар төлөвлөх, гудамжны гэрэлтүүлэгт сэргээгдэх эрчим хүч (нар, салхи)-ийг ашиглахаар тусгах; - Инженерийн байгууламж, шугам сүлжээний эх үүсвэр, хангамжийн тооцоо, судалгаа, төлөвлөлтийн шийдлийг одоо боловсруулагдаж байгаа зураг төслийн тооцоо, судалгаатай уялдуулсан байх;
10	<p>Ерөнхий төлөвлөгөө боловсруулахад тавигдах онцгой нөхцөл</p>	<ul style="list-style-type: none"> - Шинээр байгуулагдах цогцолборын нийгэм эдийн засгийн хөгжил, дэд бүтэц, байгаль орчин, хөрөнгө оруулалт болон нутаг дэвсгэрийн бүсчлэл, газар зохион байгуулалт, төлөвлөлтийн шийдэлтэй холбогдох асуудлаар хот байгуулалтын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагатай зөвшилцөн, Эрдэнэт хотын хөгжлийн чиг хандлага, төлөвлөлтийн үндсэн зарчмуудтай уялдуулах; - Авто замын мастер төлөвлөгөө, одоо хийгдсэн болон төлөвлөгдөж буй дэд бүтэцтэй уялдуулан төлөвлөх; - Байгаль цаг уурын ижил нөхцөлд оршдог дэлхийн хэмжээний их сургуулиудын хотхоныг төлөвлөлтийн стандарт, барьж байгуулсан туршлага зэргийг сайтар судлан цогцолборын төлөвлөлтөд тусгах, /шаардлагатай тохиолдолд зарим барилгын зориулалтаас хамаарч өндөр барилгыг төлөвлөж болно/ байхаар бодолцох; - Цогцолборын зам тээврийн сүлжээг тухайн бүс нутгийн авто замын сүлжээтэй уялдуулан төлөвлөх, цаашид ачаалахгүй байх нөхцөлийг хангахаар тусгах; - Цогцолбор доторх авто зам, явган зам, талбай, хичээлийн байр, бусад зориулалтын барилга байгууламжийн орц, гарцыг хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн зорчих нөхцөлөөр хангагдсан байх; - Хүрээлэн буй орчин, байгаль-экологид сөрөг нөлөөгүй, хөрс, ус, агаарын бохирдолгүй орчныг бүрдүүлсэн менежментийн оновчтой шийдлийг төлөвлөлтөд тусгах; - Цогцолборын инженерийн хангамж, эх үүсвэрийн техник, технологийн оновчтой шийдэл бүхий эдийн засгийн өндөр үр ашигтай, орчин үеийн

		<p>технологитой, байгаль орчинд ээлтэй байх төлөвлөлтийн шийдлийг дэвшүүлэх;</p> <ul style="list-style-type: none"> - Хог хаягдлын дэвшилтэд менежментийн саналыг тусгах; - Шугам сүлжээний хамгаалалтын зурвас, улаан шугамыг тусгасан байх; - Олон улсын жишиг, стандартад нийцсэн орчин үеийн "Ухаалаг хот" (Smart city)-ын зарчимд нийцсэн инженерийн дэд бүтцийн шийдлийг боловсруулах; - Нэг хүнд ногдох ногоон байгууламж, цэцэрлэгжүүлэлт, байгаль хамгааллын оновчтой шийдлийг бүрэн тусгах; - Авто, дугуйн, явган зам, гудамж, талбай, орц гарц болон барилга байгууламжид хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан, хүртээмжтэй нөхцөлийг бүрдүүлэх; - Боловсруулсан усыг ашиглах, сэргээгдэх эрчим хүч, хийн хангамжийн шийдлүүдийг судлан тусгах; - Эрчим хүчний хангамжийг байгаль орчин, цаг уурын нөхцөлд тохируулан эдийн засгийн үр ашигтай байхаар сонгон тусгах /сэргээгдэх эрчим хүч, хийн хангамж/; - Ундны болон ахуйн хэрэгцээний усны хангамжийн асуудлыг онцгой судлан, эдийн засгийн хувьд оновчтой байдлаар төлөвлөлтийн шийдлийг гаргах; - Инженерийн хэсэгчилсэн хангамжийн төлөвлөлт, харьцуулалт, эдийн засгийн үр ашгийг тооцож, оновчтой хувилбарыг тооцон тусгах; - Орчин үеийн шинэ дэвшилтэт, техник технологийн шийдэл бүхий цэвэрлэх байгууламж, эрчим хүчний бие даасан системийг судлан төлөвлөлтөд тусгах; - Хөрөнгө оруулалтын эх үүсвэрийг шийдвэрлэх талаар санал боловсруулах; - Хөгжлийн ерөнхий төлөвлөгөө боловсруулах явцад ажлын даалгаварт тусгагдаагүй, орхигдсон ажлыг тухай бүрт нь тодорхойлох, тусгах; - Зураг төсөлд тодорхой ишлэл авсан техникийн баримт бичгийг тодорхой заах, холбогдох тооцоо, судалгааг тайлбарт нарийвчлан тусгах; - Газар хөдлөлийн баллыг нарийвчлан тооцсон байх; - Төмөр замын чигээс 2 тийш тус бүр 60м хамгаалалтын бүсийг тооцон тусгах;
11	Боловсруулах хугацаа	- Гэрээ байгуулсан өдрөөс хойш 6 сарын хугацаанд;
12	Шаардагдах хөрөнгийн хэмжээ, эх үүсвэр	- "Эрдэнэт Үйлдвэр" ТӨҮГ,төгрөг

13	Захиалагч байгууллага	<ul style="list-style-type: none"> - Боловсрол, шинжлэх ухааны яам; - ШУТИС-ын харьяа Эрдэнэт цогцолбор дээд сургууль;
14	Гүйцэтгэгч байгууллага	<ul style="list-style-type: none"> - Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай, хуулийн дагуу Хот байгуулалтын баримт бичиг боловсруулах тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгж, байгууллагаар сонгон шалгаруулж гүйцэтгүүлэх;
15	Зөвшөөрөлцөх байгууллага	<ul style="list-style-type: none"> - Сургалт- эрдэм шинжилгээ -үйлдвэрлэлийн цогцолборын төлөвлөлтийн концепци загвар болон ерөнхий төлөвлөгөөг боловсруулах шатанд БХБЯ, БШУЯ, БХТ, Орхон аймгийн ЗДТГ, ГХБХБГ, ерөнхий архитектор болон бусад мэргэжлийн албад, дэд бүтцийн хангагч байгууллагуудтай зөвшилцөж, санал авах; - Ерөнхий төлөвлөгөөг хот төлөвлөлт, архитектурын болон инженерийн дэд бүтцийн орон тооны бус мэргэжлийн зөвлөлийн хурлаар тус тус хэлэлцүүлж, зөвлөмжийг авах; - Ерөнхий төлөвлөгөөний баримт бичгийг БШУЯ болон БХБЯ-ны Шинжлэх ухаан, технологийн зөвлөлийн хуралдаан, БШУ-ны сайдын зөвлөл, БХБ-ын сайдын зөвлөлийн хуралдаанаар тус тус хэлэлцүүлэх; - Хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний баримт бичигт экспертизийн дүгнэлт гаргуулах;
16	Батлах	<ul style="list-style-type: none"> - Хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг "Хот байгуулалтын тухай" хуулийн 8.1.1 дэх заалтын дагуу аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлаар хэлэлцүүлж батлуулах;
17	Даалгаварт тусгагдаагүй ажил	<ul style="list-style-type: none"> - Даалгаварт тусгагдаагүй ажлыг нэмэлт нөхцөлөөр гүйцэтгэж болох ба үүнийг гэрээний тусгай нөхцөлөөр тодорхойлно;

ХЯНАСАН:

БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ ЯАМНЫ
 ДЭЭД БОЛОВСРОЛЫН БОДЛОГЫН
 ХЭРЭГЖИЛТИЙГ ЗОХИЦУУЛАХ ГАЗРЫН
 ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
 ГҮЙЦЭТГЭГЧ


 Х.ТАМИР

БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ ЯАМНЫ
 ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ХЭЛТСИЙН
 ДАРГА

С.НАНСАЛМАА

"ЭРДЭНЭТ ҮЙЛДВЭР" ТӨҮГ-ЫН СТРАТЕГИ,
 ХӨГЖЛИЙН ГАЗРЫН ДАРГА


 П.ЭНХБАТ
 21/20. 25

“ЭРДЭНЭТ ҮЙЛДВЭР” ТӨҮГ-ЫН БАРИЛГА
БАЙГУУЛАМЖИЙН ХЯНАЛТ,
ТӨЛӨВЛӨЛТИЙН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.БАТБАЯР

ОРХОН АЙМГИЙН ЗДТГ-ЫН ХОХБТХ-ИЙН
ДАРГА

С.ДАВААДОРЖ

ОРХОН АЙМГИЙН ГАЗРЫН ХАРИЛЦАА
БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ГАЗРЫН
ДАРГА

Д.ЦОЛМОН

ОРХОН АЙМГИЙН ЕРӨНХИЙ АРХИТЕКТОР

Ц.БАЯРЖАРГАЛ

“ИХ, ДЭЭД СУРГУУЛИУДЫН ХӨРӨНГИЙН
МЕНЕЖМЕНТИЙН ТӨВ” ТӨҮГ-ЫН
ЗАХИРЛЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ

П.ЛХАГВАСҮРЭН

ШИНЖЛЭХ УХААН, ТЕХНОЛОГИЙН ИХ
СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ

Т.НАМНАН

БОЛОВСРУУЛСАН:

“ИХ, ДЭЭД СУРГУУЛИУДЫН ХӨРӨНГИЙН
МЕНЕЖМЕНТИЙН ТӨВ” ТӨҮГ-ЫН
МЕНЕЖЕР

Ш.БАТ-ЭРДЭНЭ

ШИНЖЛЭХ УХААН, ТЕХНОЛОГИЙН ИХ
СУРГУУЛИЙН ХАРЬЯА ЭРДЭНЭТ
ЦОГЦОЛБОР СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ

Д.ЗОРИГТХҮҮ